



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Улаанбаатар хот, Төв аймгийн Засаг дарга
Төрийн сангийн Засаг дарга, МУ-ийн
Улаанбаатар хот, Төв аймгийн Засаг дарга
Төрийн сангийн Засаг дарга

2016.02.25 № 3/242

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Татварын ерөнхий газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Татварын ерөнхий газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хийсэн сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй дараах асуудлууд илэрсэн болно. Үүнд:

- Үнэт цаас, тооцоот маягтын үлдэгдэлийг тулган баталгаажуулахад санхүүгийн тайланд тайлагнасан үнэт цаас, тооцоот маягтын үлдэгдэл тооллогын илтгэх хуудас, тайлангийн дүнгээс /тооцоот маягт 210,800 ширхэгээр дутуу/ бүртгэсэн;
- Тайлант онд эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 8.3 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан, урсгал төсвийн /Багаж хэрэгсэл сэлбэг, мэдээлэл технологийн үйлчилгээ/-ний зардлаас нийт 170.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн,
- Аудитын явцад орлогын албан татварын тэмдэгийн орлогыг тулган баталгаажуулахад тус байгууллагын Төрийн сангийн харилцах дансанд орсон орлогын тулгалтаар санхүүгийн тайланд уг ажил гүйлгээг буруу бүртгэснээс дараах бүртгэлийн алдаа, зөрчил гарсан.

Тухайлбал:

- Үнэт цаасны захиалга өгч, төлбөрөө шилжүүлсэн аж ахуй нэгж байгууллагуудаас тушаасан орлогыг УСНББОУС 9 болон 19-ийн дагуу бүртгээгүйгээс нийт 2,561.5 сая төгрөгийн ажил гүйлгээг санхүүгийн програмд бүртгэж, тусгалгүй шууд тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- Үнэт цаасыг борлуулах үнэ болон өртгийн зөрүүгээс үүссэн нийт 766.9 сая төгрөгийн олз үүссэн боловч тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- Байгууллагуудаас захиалсан үнэт цаас, тооцоот маягтын орлогыг санхүүгийн тайланд шууд орлогоор хүлээн зөвшөөрч, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээг тооцоо үүсгэж, санхүүгийн програмд бүртгээгүйгээс тайлангийн эцсийн өдөр өр төлбөрийн дансыг нийт 52.9 сая төгрөгөөр бууруулж, бусад орлогоор бүртгэснээс тайлант үеийн үр дүнг илүү илэрхийлсэн байна.

Эдгээр нь АДБОУС-250, 1230, Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн Оршин байх, Үнэн зөв байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4.1 мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.3, НББОУС 18, УСНББОУС 9-ийн 28-д (а)-(д), УСНББОУС 19, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад УОО-ын бүртгэл-4.63, Нягтлан бодох бүртгэлийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 5.1-дэх заалтууд, ТЕГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимтой тус тус нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил нь 2,792.7 сая төгрөг бөгөөд материаллаг байдлын түвшингээс 2,643.0 сая төгрөгөөр давсан тул бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол Татварын ерөнхий газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

УАГ-ын Санхүүгийн аудитын
газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер:
Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг:
gunjigmaag@audit.gov.mn

Аудитор: П.Чанцалдулам
Утас: 261740
chantsaldulamp@audit.gov.mn

Монгол Улсын Үндэсний
аудитын газар

Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46
Бага тойруу 6

Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

ХУУДАС

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	3
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	3
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа.....	4
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	4
5. Материаллаг байдал.....	6
6. Дотоод хяналт.....	6
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар.....	6
8. Шилэн дансны мэдээлэл.....	7
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	8
10. Гол, онцлог гүйлгээний талаар.....	8
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	9
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	12
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	12
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	12
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	13
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
17. Аудитын гэрчилгээний талаар санал дүгнэлт.....	13

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Татварын ерөнхий газрын аппаратын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ/2016/05/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Татварын ерөнхий газрын аппаратын 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Татварын ерөнхий газрын аппаратын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 2 дугаар сарын 15-наас 2016 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын Нэгтгэсэн тайлангийн аудитын алба /НТАА/-ны аудитор П.Чанцалдулам хэрэгжүүлэв.

Татварын ерөнхий газрын аппаратын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 25-ны 01-3/261 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2016 оны 2 дугаар сарын 15-наас 2016 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2016 оны 2 дугаар сарын 25-нд Татварын ерөнхий газрын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт,

санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн эх үүсвэрийн ангилал, Төсвийн бусад мэдээллийн болон Балансын дансны ангиллыг 4-5 дугаар хавсралт, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 55 дугаар тушаалаар Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалаар Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал”-ыг ашиглаж байна.

Харин тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулиудын нэг болох Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өөрчлөлт оруулсан мөн “Журам шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 341 дүгээр тушаалаар Сангийн сайдын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 32 дугаар тушаалыг хүчингүй болгож, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус бүр дагаж мөрдөхөөр заасан байна.

Мөн “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, “Төсвийн зарим анхдагч ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 150 дугаар тушаалын 1, 2, 3 дугаар хавсралтыг тус тус хүчингүйд тооцсон байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ татварын алба, татвар төлөгч шударгаар биелүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд Үндэсний татварын албаны эрхэм зорилго орших ба төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх үндсэн зарчмуудыг баримтлан ажиллаж байна.

Үндэсний татварын албаны чиг үүрэг нь:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах,
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих,
- Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 болон 16.4.5-д заасны дагуу Татварын ерөнхий газрын дэд дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Татварын ерөнхий газрын аппаратын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 12 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Аудитын нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэх явцад гарсан зарим онцлог ажил гүйлгээнээс дурдвал дараах байдалтай байна.

- ТӨХ-ны 2015 оны 3/1916 дугаар тогтоолоор Дэлхийн банкны засаглалыг дэмжих төслийн “Монголын татварын албаны хураалтын үйл ажиллагаа болон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл” хөтөлбөрөөс тоног төхөөрөмж 162.5 сая, тавилга эд хогшил 13.5 сая, нийт 176.0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авсан байна.
- Байгууллагаас авах авлагын 99.3 хувь буюу 1,997.1 сая төгрөг нь үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг улсын төсөвт төвлөрүүлснээс үүссэн авлагын үлдэгдэл байна. Үүний 1,747.9 сая төгрөг нь 2013 онд үүссэн бол 249.2 сая төгрөгийг тайлант онд нэмж бүртгэн Сангийн яамтай тооцоо нийлж, баталгаажуулжээ.
- Няравын кассын тайлангаар бэлэн мөнгөний данс эхний үлдэгдэлгүй, тайлант хугацаанд харилцах данснаас нийт 169.9 сая төгрөгийн орлогыг бүртгэж, 169.8 сая төгрөгийг зарцуулж, 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 0.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Харин няравын төрийн банкин дахь 104900024251 тоот харилцах дансны хуулгаар тайлант хугацаанд нийт 280.4 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдэж, оны эцэст үлдэгдэлгүй гарсан байна.

Татварын ерөнхий газрын даргын 2013 оны 104 дүгээр тушаалаар баталсан “Үндэсний татварын албаны Нягтлан бодох бүртгэлийн бодлого, горим”-ыг мөрдөн ажиллаж байна.

Татварын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “энгийн” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тайлант хугацаанд Татварын ерөнхий газрын аппарат нь санхүүгийн бүртгэлээ Интер-Актив ХХК-ийн санхүүгийн “Emerald”, цалингийн “Payroll” програмаар тус тус хөтөлж, санхүүгийн тайланг гаргасан байна.

Тав. Материаллаг байдлыг тодорхойлох

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2 хувиар тооцож 149.7 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В-1/

Зургаа. Дотоод хяналтын талаар

ТЕГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /ХШҮДАГ/ нь 2015 онд газрын дарга, татварын улсын ахлах байцаагч 1, татварын улсын байцаагч 4 нийт 6 орон тоотой /*үүнээс санхүүгийн дотоод аудитыг 2 байцаагч хавсран гүйцэтгэсэн*/ үйл ажиллагаагаа явуулж иржээ.

ХШҮДАГ-ын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Татварын албаны хүний нөөцийн болон технологийн чадавхийг бэхжүүлэх, цахим технологи, инноваци, мэдлэгт суурилсан татварын удирдлагыг бэхжүүлнэ” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх 15 чиглэлд аудит хийхээр төлөвлөн гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 12 зөвлөмж өгч, ТЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ТЕГ-ын даргын тушаалаар үүрэг чиглэл өгч ажилласан байна.

ТЕГ-ын ХШҮДАГ-аас тус байгууллагын аппаратын 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд тухайлсан аудит хийж, зөвлөмж өгөөгүй ба байгууллагын дотоод бүтэц нэгжүүдийн сар бүрийн төлөвлөгөөт ажлын биелэлтэд үнэлгээ хийж, дүнг нэгтгэн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад үнэт цаас, тооцоот маягын бүртгэл, түүний зарцуулалтад анхаарал хандуулах шаардлагатай байна.

Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар

2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Татварын ерөнхий газрын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

2015 оны төсвийн тухай хуулиар Татварын ерөнхий газрын аппаратын нийт санхүүжилтийн зардлыг 6,628.9 сая төгрөгөөр баталснаас урсгалаас санхүүжих 3,023.2 сая, өөрийн орлогоор санхүүжих 3,288.8 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг тус тус баталсан байна.

Тус байгууллага нь 2015 онд гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал төсвийн санхүүжилтэд 2,924.1 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,317.9 сая, үйл ажиллагааны бус орлогоос 172.6 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 1,094.9 сая, бусад орлого болон жижиг мөнгөн сангийн үлдэгдлээс санхүүжих 2.4 сая төгрөгийн орлогыг тус бүр орлогоор бүртгэж, урсгал зардалд 5,234.5 сая төгрөгийг зарцуулж, 1,277.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Өөрийн орлогын гүйцэтгэлийн талаар : Нийт өөрийн орлогын гүйцэтгэл 78 хувь буюу 2,492.0 сая төгрөг бөгөөд орлогын төлөвлөгөө 22 хувь буюу 796.8 сая төгрөгөөр тасарсан байна.

Өөрийн орлогын судалгаа:

/мян.төг/				
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	1,910,060.8	2,317,908.6	(407,847.8)
2	Туслах үйл ажиллагааны орлого	1,378,796.0	174,108.4	1,204,687.6
3	Дүн	3,194,563.3	2,492,017.1	796,839.8

Найм. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад:

- Аудитын явцад тус байгууллагын ВЭБ хуудас дахь ил тод байдал-“Шилэн данс цэс”-д байршуулсан мэдээлэлтэй танилцахад 2015 оны төсөв, төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 2,738.0 сая төгрөгийн 24 ширхэг, зарлагын нийт 2,622.3 сая төгрөгийн 61 ширхэг ажил гүйлгээг тус тус байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан байна.
- Мөн ТЕГ-ын ХШҮДАГ-аас 2015 онд хийсэн аудитын тайлантай танилцахад тус байгууллагын үйл ажиллагааны ил тод байдалд үнэлгээ хийж, дараах байдалтай үнэлжээ.
 - Монгол Улсын Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Татварын албаны хэмжээнд төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор тус бүлгийн үнэлгээг 4 бүлэг үзүүлэлтийн хүрээнд хийж, 87.50 оноогоор үнэлсэн байна. Үүнд:

Дд	Үзүүлэлт	ТЗУГ	ТТҮГ	ХЭЗХ	СХОХ	Нийт
1	Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	87.50	90.00	90.00		88.50
2	Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	84.00				84.00
3	Төсөв, санхүүгийн ил тод байдал				90.00	90.00

4	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	Үнэлээгүй				
Нийт		85.91	90.00	90.00	90.00	87.50

Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд холбогдох дансад нийт 12 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Татварын ерөнхий газрын аппаратын 2015 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан болон бусад ажил гүйлгээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А-276 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөө хуваарийн дагуу завсрын аудитыг хийхээр төлөвлөсөн боловч дараах шалтгааны улмаас гүйцэтгээгүй болно. Үүнд:

- Завсрын аудитыг хийлгэх боломжгүй, он гаргаад хуулийнхаа хугацаанд аудитаа хийлгүүлэх талаар МУ-ын Ерөнхий аудитор А.Зангадад уламжилна.
- Татварын хууль шинэчлэгдэх гээд 3 төрлийн хуулийн төсөл дээр ажиллаж байна. Мөн 75000 ААНБ-ын тайланг ил тод болгох, улсын төсөв тасарсантай холбогдон орлого бүрдүүлэх, төсвийн тодотголтой холбоотой хийх ажил их, Сангийн яам, Гаалийн ерөнхий газраас хүртэл хүмүүс татаж, ажиллуулахаар болж ажил их байгаа нөхцөлд аудит хийлгэх боломжгүй байгаагаа завсрын аудит хийх төлөвлөгөө, хөтөлбөр танилцуулах уулзалтын үеэр ТЕГ-ын дарга: Ариунсан уламжилсан тул завсрын аудитыг төлөвлөөний дагуу хийж чадаагүй болно.
- Тайлант оны 12 дугаар сард тус байгууллагын 3 дугаар улирал хүртэлх харилцах, касс, жижиг мөнгөн сангийн тайланд түүвэр хийж, холбогдох баримт материалуудтай танилцсанаас бусад горим, сорилыг хэрэгжүүлээгүй болно. Завсрын аудит хийлгээгүйгээс тус байгууллагад үүссэн бүх эрсдэл нь жилийн эцсийн аудитад нөлөөлсөн болно.

Арав. Гол, онцлог гүйлгээний талаар

Татварын ерөнхий газрын аппаратын төсвийн 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүн бүхий дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

- Урсгал санхүүжилтийн харилцах данснаас тайлант онд зардлын эдийн засгийн ангиллаар багаж хэрэгсэл 212.0 сая, БҮТЭЗ 15.5 сая, улсын мэдүүлгийн маягт хэвлэх бэлтгэх зардалд 1,948.5 сая, мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 404.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардалд 222.5 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 65.3 сая,

урсгал засварт 33.4 сая, зочин төлөөлөгчийн зардалд 78.7 сая, гадаад томилолтын зардалд 136.7 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

- Тайлант хугацаанд үнэт цаас болон тооцоот маягт хэвлүүлэхэд нийт 1,944.5 сая төгрөгийг төлсөн байна. Үүнд: Үндэсний үнэт цаас ХХК-д 1,448.3 сая, Мөнхийн үсэг групп ХХК-д 496.2 сая төгрөгийг тус тус төлжээ.
- Интерактив Би Ай ХХК-д санхүүгийн болон цалингийн програмын төлбөрт 140.0 сая, Интерактив ХХК-д ил тодын хуулийг хэрэгжүүлэх сайтын програмын төлбөрт 84.0 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.
- 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Налайх сан булаг ХХК-иас ширээ сандал, шүүгээ худалдан авахаар нийт 30.0 сая төгрөгийн төлбөрийг төлсөн байна.

Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад Татварын ерөнхий газрын хэмжээнд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Татварын ерөнхий газар нь 2012 онд зохион байгуулагдсан Үндэсний Татварын албаны 20 жилийн ойд зориулсан арга хэмжээний баримтат кино, бичлэг хийхтэй холбогдуулан United pictures ХХК-тай гэрээ байгуулан холбогдох ажил гүйлгээг бүртгэлд тусгажээ. Гэвч 2015 оны санхүүгийн тайлангаар тус байгууллагатай авлагын 1.5 сая, өглөгийн 27.5 сая төгрөгийн тооцооны үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Энэ нь аудитын батламж мэдэгдлийн *Оршин байх*: “санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д “эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2016 оны тайлангийн жилд United pictures ХХК-тай авлага, өглөгийн тооцоог нийлж, баталгаажуулан, авлага, өглөгийн тооцоог зэрэг үүсгэн бичсэн бүртгэлийн буруу бичилтийг залруулан бүртгэхийг ТЕГ-ын удирдлагад зөвлөмж болгох;

2. Аудитын явцад тайлант хугацаанд худалдан бэлтгэсэн болон бусдад олгосон үнэт цаас, тооцоот маягтын ажил гүйлгээг тулган баталгаажуулахад бараа материалын дэлгэрэнгүй журналаар уг дансны эхний үлдэгдэл 3,041,075 ширхэг буюу 80.2 сая төгрөг, тайлант хугацаанд нийт 194,700,048 ширхэг буюу

1,914.3 сая төгрөгийн үнэт цаас, тооцоот маягтыг орлогоор авч, 194,387,260 ширхэг буюу 1,900.8 сая төгрөгийн зарцуулалт хийж, 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3,111,780 ширхэг буюу 81.4 сая төгрөгийн үнэт цаас, тооцоот маягтын үлдэгдэлтэй байна.

Үнэт цаас, тооцоот маягтын үлдэгдэл тооцоо-/2015 оны 12 сарын 31/

Мян/төг

№	Үнэт цаасны төрөл	Эхний үлдэгдэл		Орлого		Зарлага		Эцсийн үлдэгдэл	
		тоо ширхэг	өртөг	тоо ширхэг	өртөг	тоо ширхэг	өртөг	тоо ширхэг	өртөг
1	Орлогын албан татварын тэмдэг		0	192,075	1,795,838.49	192,004	1,794,604.75	71	1,233.74
2	Тооцоот маягтууд	2,799	67,950.50	2,625	118,461.80	2,383	106,197.95	3,041	80,214.35
	Дүн	2,799	67,950.50	194,700	1,914,300.29	194,387	1,900,802.70	3,112	81,448.09

Гэвч 2015 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Эд хөрөнгийн тооллого хийх тухай” А/248 дугаар тушаалаар баталсан тооллогын комиссын илтгэх хуудас, тооллогын бүртгэлээр үнэт цаас, тооцоот маягтын үлдэгдлийг /орлогын албан татварын тэмдэг-хүчинтэй 28,220 ширхэг, хүчингүй болсон 1,122,982 ширхэг/, /тооцоот маягт-15 нэр төрлийн 3,251,875 ширхэг/-ийг тус тус тоолж, баталгаажуулсан байна.

Дээрхээс үзэхэд санхүүгийн тайланд тайлагнасан үнэт цаас, тооцоот маягтын үлдэгдэл тооллогын илтгэх хуудас, тооллогын бүртгэлийн дүнгээс тооцоот маягт 210,800 ширхэгээр дутуу бүртгэгдсэн байна. Энэ нь үнэ төлбөргүй тооцоот маягт учир санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнаагүй гэсэн тайлбарыг өгсөн.

Эдгээр нь АДБОУС-250 “Санхүүгийн тайлангийн аудитад хууль тогтоомж, дүрэм журмыг анхаарах”, АДБОУС-1230 “Гүйцэтгэсэн аудитын горим, олж авсан аудитын нотлох зүйлсийн баримтжуулалт”, УСНББОУС 12-ын 15-д “Бараа материалыг 16 эсвэл 17-р зүйлд зааснаас бусад тохиолдолд өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлнэ”, аудитын батламж мэдэгдлийн *Оршин байх*: “санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх”; *Үнэн зөв байдал*: “аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4.1-д “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу тухайн байгууллагад бүртгэлтэй хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай тоолж, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд үнэн зөв толилуулах, үнэт цаас тооцоот маягтын зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, үнэт цаас тооцоот маягтын бүртгэл, бүртгэлд тусгах арга аргачлалыг тодорхой болгон тушаалаар баталгаажуулж, ТЕГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимд нэмэлт өөрчлөлтөөр тусгаж, мөрдөхийг ТЕГ-ын удирдлагад зөвлөмж болгох;

САГ/2016/05/СТА-ТШЗ

3. Тайлант хугацаанд тус байгууллагад хөрөнгө оруулалтын зардал батлагдаагүй бөгөөд 2015 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал төсвийн /Багаж хэрэгсэл сэлбэг, мэдээлэл технологийн үйлчилгээ/ зардлаас нийт 170.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэжээ. Үүнд:
- Тавилга хэрэгсэл 30.0 сая;
 - Санхүүгийн болон цалингийн програм хангамж 140.0 сая төгрөг байна.

Мөн тайлант онд эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр Нийслэлийн татварын даргын 2015 оны А/179 дүгээр тушаалыг үндэслэн нийт 8.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

Эдгээр нь АОУС-250 “Санхүүгийн тайлангийн аудитад хууль тогтоомж, дүрэм журмыг анхаарах”, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгийн хөдөлгөөн хийхийг таслан зогсоож, урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх, хөрөнгө бэлтгэх санхүүжилтээ тухайн жилийн төсвийн тухай хуулинд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвлөн батлуулж, зарцуулж байхыг ТЕГ-ын удирдлагад зөвлөмж болгох;

4. Мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлогын дансдын тулган баталгаажуулалтаар мөнгөн гүйлгээ болон үр дүнгийн тайлан дараах орлогуудаар ялгаатай тайлагнагдсан байна. Тухайлбал:
- Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих 1,094.9 сая;
 - Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг Сангийн яам жилийн эцэст улсын төсөвт татан төвлөрүүлж, авлагаар бүртгэсэн 249.2 сая;
 - Бусад орлогоор хүлээн зөвшөөрч, өр төлбөрийг бууруулан бүртгэсэн 52.9 сая;
 - Үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрч үндсэн хөрөнгийг орлогод авсан 295.7 сая төгрөгийн ажил гүйлгээ байна.

Дээрх ажил гүйлгээнээс шинжлэн дүгнэхэд тус байгууллага үнэт цаас, тооцоот маягтын захиалгыг авч, холбогдох байгууллагуудаар нь санхүүгийн програмд тооцоо үүсгэж бүртгэдэггүй, тусдаа Excel-ийн файлд бүртгэсэн бүртгэлээс жилийн эцэст өглөгийн тохируулга бичилт хийж, нийт 52.9 сая төгрөгийг бусад орлогоор бүртгэснээс санхүүгийн үр дүнгийн тайлангийн тайлант оны үр дүн илүү илэрхийлэгдсэн байна. Иймд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого болон үнэт цаас, тооцоот маягтын зарцуулалтыг тулган баталгаажуулахад хүндрэлтэй байсан.

Иймд аудитын явцад орлогын албан татварын тэмдэгийн орлогыг тулган баталгаажуулах зорилт тавьж, тус байгууллагын Төрийн сангийн харилцах

дансанд орсон орлогыг тулган баталгаажуулахад санхүүгийн тайланд уг ажил гүйлгээг буруу бүртгэснээс дараах бүртгэлийн алдаа, зөрчил гарсан. Тухайлбал:

- Үнэт цаасны захиалга өгч, төлбөрөө шилжүүлсэн аж ахуй нэгж байгууллагуудаас тушаасан орлогыг УСНББОУС 9 болон 19-ийн дагуу бүртгээгүйгээс нийт 2,561.5 сая төгрөгийн ажил гүйлгээг санхүүгийн програмд бүртгээгүй боловч Төрийн сангийн харилцах дансанд тушаасан мөнгөн дүнгээр шууд тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- Үнэт цаасыг борлуулах үнэ болон өртгийн зөрүүгээс үүссэн нийт 766.9 сая төгрөгийн олз үүссэн боловч тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- Байгууллагуудаас захиалсан үнэт цаас, тооцоот маягтын орлогыг санхүүгийн тайланд бүртгэхдээ шууд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэснээс санхүүгийн тайлангийн эцсийн өдөр буюу 2015 оны 12 дугаар сарын 31-д байгууллагад өгөх өглөгийн үлдэгдлийг тохируулан бүртгэхийн тулд excel дээрх бүртгэл, тооцооллоосоо шахаж, тооцооны дансны эхний эцсийн үлдэгдлийн зөрүү буюу нийт 52.9 сая төгрөгөөр өр төлбөрийн дансыг бууруулж, бусад орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Эдгээр бүртгэлийн бичилтүүд НББОУС 18, УСНББОУС 9-ийн 28-д (а)-(д) хүртэлх бүх нөхцөл хангагдсан тохиолдолд бараа борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ, УСНББОУС 19-ийн 1 болон 18 (а) Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад УОО-ын бүртгэл 4.63-д “Ажил үйлчилгээг гүйцэтгэж хүлээлгэн өгөх, бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэхээс өмнө үнийг нь урьдчилан авсан тохиолдолд урьдчилж орсон орлого дансанд бүртгэж, цаашид ажил үйлчилгээг гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн үед орлогоор хүлээн зөвшөөрнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх”; мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө”, ТEG-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, гормын 4.8-д “Орлогын бүртгэл”-ийн 5, 4.8.2-т “Орлогын бүртгэлийн горим”-ын 6-тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББОУС 18, УСНББОУС 9, 19 болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, ТEG-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимын 4.8-д “Орлогын бүртгэл”-ийн дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгаж, санхүүгийн тайланг үнэн зөв стандартын дагуу тайлагнаж байхыг ТEG-ын удирдлагад зөвлөмж болгох;

Арван хоёр. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар санхүүгийн тайланд материаллаг бус залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Татварын ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайлан болон харьяа нийслэл, дүүрэг, аймаг орон нутгийн Татварын газар, хэлтсүүдтэй үнэт цаас, тооцоот маягтуудын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан бүртгэл, тайлагнал болон тооцоот маягтын орлогын бүртгэлийг тулган шалгах.

Арван тав. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Татварын ерөнхий газрын аппаратын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,821.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба дээр дурдсан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 4 зөвлөмж өгсөн болно.

Арван зургаа. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Үндэсний аудитын газраас Татварын ерөнхий газрын аппаратын 2014 оны санхүүгийн тайланг тус газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын түүвэрт хамруулан шалгаж, бие даасан дүгнэлт, зөвлөмж өгөөгүй байна.

Татварын ерөнхий газрын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 12/1945 дугаар албан бичгийн хамт Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Арван долоо. Хязгаалалттай санал дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Татварын ерөнхий газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлсэн байна.

Аудитын тайланд хавсралт тайлан /8 хуудас/-ыг хавсаргав.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

2016 оны 2 дугаар сар

САГ/2016/05/СТА-ТШЗ



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2015 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

УАГ-ын Санхүүгийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас: 261663
Цахимхаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Аудитор: П.Чанцалдулам
Утас: 261740
Цахимхаяг:
chantsaldulamp@audit.gov.mn

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар

Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IY байр
Улаанбаатар хот 15160
Монгол Улс

Цахим хуудас: www.audit.mn

Менежментийн захидал

Асуудал 1

Авлага өглөгийн талаар

Асуудал 2

Бараа материалын талаар

Асуудал 3

Үндсэн хөрөнгийн талаар

Асуудал 4

Бүртгэл тайлагналын талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Татварын ерөнхий газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Татварын ерөнхий газрын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах явдал бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Татварын ерөнхий газрын нягтлан бодогч С.Санжидмаа, нягтлан бодогч Г.Гантуяа болон санхүүгийн бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал

Асуудал.1 Авлага, өр төлбөрийн талаар

ҮАГ-ын ажиглалт

Татварын ерөнхий газар нь 2012 онд зохион байгуулагдсан Үндэсний Татварын албаны 20 жилийн ойд зориулсан арга хэмжээний баримтат кино, бичлэг хийхтэй холбогдуулан United pictures ХХК-тай гэрээ байгуулан холбогдох ажил гүйлгээг бүртгэлд тусгажээ. Гэвч 2015 оны санхүүгийн тайлангаар тус байгууллагатай авлагын 1.5 сая, өглөгийн 27.5 сая төгрөгийн тус тус тооцооны үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Энэ нь аудитын батламж мэдэгдлийн *Оршин байх*: “санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д “эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

2016 оны тайлангийн жилд United pictures ХХК-тай авлага, өглөгийн тооцоог нийлж, баталгаажуулан, авлага, өглөгийн тооцоог зэрэг үүсгэн бичсэн бүртгэлийн буруу бичилтийг залруулан бүртгэх;

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2016 оны 06 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэл

- Дансны бичилт буруу хийгдсэн байх;
- Холбогдох стандарт, хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх;

Үйлчлүүлэгчийн хариу

- Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал

Асуудал.2 Бараа материалын талаар

ҮАГ-ын ажиглалт

Үнэт цаас, тооцоот маягтын үлдэгдлийг тулган баталгаажуулахад санхүүгийн тайланд тайлагнасан үнэт цаас, тооцоот маягтын үлдэгдэл тооллогын илтгэх хуудас, тайлангийн дүнгээс /тооцоот маягт 210,800 ширхэгээр дутуу/ бүртгэгдсэн байна. Энэ нь үнэ төлбөргүй тооцоот маягт учир санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнаагүй гэсэн тайлбарыг өгсөн.

Эдгээр нь АДБОУС-250 “Санхүүгийн тайлангийн аудитад хууль тогтоомж, дүрэм журмыг анхаарах”, АДБОУС-1230 “Гүйцэтгэсэн аудитын горим, олж авсан аудитын нотлох зүйлсийн баримтжуулалт”, УСНББОУС 12-ын 15-д “Бараа материалыг 16 эсвэл 17-р зүйлд зааснаас бусад тохиолдолд өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлнэ”, аудитын батламж мэдэгдлийн *Оршин байх*: “санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх”; *Үнэн зөв байдал*: “аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх”, ТБОНӨ-ийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4.1-д “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу тухайн байгууллагад бүртгэлтэй хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай тоолж, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд үнэн зөв толилуулах, үнэт цаас тооцоот маягтын зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, үнэт цаас тооцоот маягтын бүртгэл, бүртгэлд тусгах арга аргачлалыг тодорхой болгон тушаалаар баталгаажуулж, ТЕГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимд нэмэлт өөрчлөлтөөр тусгаж, мөрдөх;

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2016 оны 06 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэл

-Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх;
-Үнэт цаас, тооцоот маягтын тайлан тооцоонд бүртгэлээр тавих хяналт алдагдах;

Үйлчлүүлэгчийн хариу

-Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал

Асуудал.3 Үндсэн хөрөнгийн талаар

ҮАГ-ын ажиглалт

Тайлант хугацаанд тус байгууллагад хөрөнгө оруулалтын зардал батлагдаагүй бөгөөд 2015 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал төсвийн /Багаж хэрэгсэл сэлбэг, мэдээлэл технологийн үйлчилгээ/ зардлаас нийт 170.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэжээ. Үүнд:

- Тавилга хэрэгсэл 30.0 сая;
- Санхүүгийн болон цалингийн програм хангамж 140.0 сая төгрөг байна.

Мөн тайлант онд эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр Нийслэлийн татварын даргын 2015 оны А/179 дүгээр тушаалыг үндэслэн нийт 8.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

Эдгээр нь АОУС-250 “Санхүүгийн тайлангийн аудитад хууль тогтоомж, дүрэм журмыг анхаарах”, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэл

-Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх;

ҮАГ-ын зөвлөмж

Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгийн хөдөлгөөн хийхийг таслан зогсоож, урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх, хөрөнгө бэлтгэх санхүүжилтээ тухайн жилийн төсвийн тухай хуулинд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвлөн батлуулж, зарцуулж байх;

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2016 оны 06 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

-Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал

Асуудал.4 Бүртгэл тайлагналын талаар

ҮАГ-ын ажиглалт

Мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлогын дансдын тулган баталгаажуулалтаар мөнгөн гүйлгээ болон үр дүнгийн тайлан дараах орлогуудаар ялгаатай тайлагнагдсан байна. Тухайлбал:

- Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих 1,094.9 сая;
- Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг Сангийн яам жилийн эцэст улсын төсөвт татан төвлөрүүлж, авлагаар бүртгэсэн 249.2 сая;
- Бусад орлогоор хүлээн зөвшөөрч, өр төлбөрийг бууруулан бүртгэсэн 52.9 сая;
- Үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрч үндсэн хөрөнгийг орлогод авсан 295.7 сая төгрөгийн ажил гүйлгээ байна.

Дээрх ажил гүйлгээнээс шинжлэн дүгнэхэд тус байгууллага үнэт цаас, тооцоот маягтын захиалгыг авч, холбогдох байгууллагуудаар нь санхүүгийн програмд тооцоо үүсгэж бүртгэдэггүй, тусдаа Excel-ийн файлд бүртгэсэн бүртгэлээс жилийн эцэст өглөгийн тохируулга бичилт хийж, нийт 52.9 сая төгрөгийг бусад орлогоор бүртгэснээс санхүүгийн үр дүнгийн тайлангийн тайлант оны үр дүн илүү илэрхийлэгдсэн байна. Иймд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого болон үнэт цаас, тооцоот маягтын зарцуулалтыг тулган баталгаажуулахад хүндрэлтэй байсан.

Иймд аудитын явцад орлогын албан татварын тэмдэгийн орлогыг тулган баталгаажуулах зорилт тавьж, тус байгууллагын Төрийн сангийн харилцах дансанд орсон орлогыг тулган баталгаажуулахад санхүүгийн тайланд уг ажил гүйлгээг буруу бүртгэснээс дараах бүртгэлийн алдаа, зөрчил гарсан. Тухайлбал:

- Үнэт цаасны захиалга өгч, төлбөрөө шилжүүлсэн аж ахуйн нэгж байгууллагуудаас тушаасан орлогыг УСНББОУС 9 болон 19-ийн дагуу бүртгээгүйгээс нийт 2,561.5 сая төгрөгийн ажил гүйлгээг санхүүгийн програмд бүртгээгүй боловч Төрийн сангийн харилцах дансанд тушаасан мөнгөн дүнгээр шууд тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн;

ҮАГ-ын зөвлөмж

НББОУС 18, УСНББОУС 9, 19 болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, ТЕГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимын 4.8-д “Орлогын бүртгэл”-ийн дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгаж, санхүүгийн тайланг үнэн зөв стандартын дагуу тайлагнаж байхыг ТЕГ-ын удирдлагад зөвлөмж болгох;

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2016 оны 06 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;

- Үнэт цаасыг борлуулах үнэ болон өртгийн зөрүүгээс үүссэн нийт 766.9 сая төгрөгийн олз үүссэн боловч тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- Байгууллагуудаас захиалсан үнэт цаас, тооцоот маягтын орлогыг санхүүгийн тайланд шууд орлогоор хүлээн зөвшөөрч, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээг тооцоо үүсгэж, санхүүгийн програмд бүртгээгүйгээс тайлангийн эцсийн өдөр өр төлбөрийн дансыг нийт 52.9 сая төгрөгөөр бууруулж, бусад орлогоор бүртгэснээс тайлант үеийн үр дүнг илүү илэрхийлсэн байна.

Эдгээр бүртгэлийн бичилтүүд УСНББОУС 9-ийн 28-д (а)-(д) хүртэлх бүх нөхцөл хангагдсан тохиолдолд бараа борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ, УСНББОУС 19-ийн 1 болон 18 (а) Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад УОО-ын бүртгэл 4.63-д “Ажил үйлчилгээг гүйцэтгэж хүлээлгэн өгөх, бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэхээс өмнө үнийг нь урьдчилан авсан тохиолдолд урьдчилж орсон орлого дансанд бүртгэж, цаашид ажил үйлчилгээг гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн үед орлогоор хүлээн зөвшөөрнө”, Нягтлан бодох бүртгэлийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх”; мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, ТЕГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, гормын 4.8-д “Орлогын бүртгэл”-ийн 5, 4.8.2-т “Орлогын бүртгэлийн горим”-ын 6-тай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэл

- Дансны бичилт буруу хийгдсэн байх;
- Данс бүртгэлд ажил гүйлгээг бүртгээгүй орхидуулах;
- Холбогдох стандарт, хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх;

Үйлчлүүлэгчийн хариу

- Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛ**

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,187,634,399.22	2,214,790,245.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,000,000.00	83,090.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	2,000,000.00	83,090.00
31110	Төгрөг	2,000,000.00	83,090.00
33	АВЛАГА	2,865,568,633.52	2,011,459,830.52
33500	Бусад авлага	2,865,568,633.52	2,011,459,830.52
33510	Байгууллагаас авах авлага	2,860,947,773.52	2,011,459,830.52
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,620,860.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	320,065,765.70	203,247,325.31
35100	Түүхий эд материал	168,270.00	1,617,982.00
35130	Эм боох материал	168,270.00	1,617,982.00
35400	Хангамжийн материал	319,897,495.70	201,629,343.31
35410	Бичиг хэргийн материал	26,958,165.00	22,509,127.30
35420	Аж ахуйн материал	211,698,361.36	81,926,636.67
35430	Сэлбэг хэрэгсэл	4,816,000.00	3,444,500.00
35440	Түлш, шатах тослох материал	2,190,000.00	4,511,444.00
35460	Хүнсний материал		149,880.00
35470	Бусад хангамжийн материал	74,234,969.34	89,087,755.34
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,734,418,286.06	6,013,492,666.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,734,418,286.06	6,013,492,666.48
39200	Биет хөрөнгө	5,099,008,532.76	4,949,123,122.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,443,083,001.00	3,443,083,001.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(300,237,150.94)	(357,690,855.59)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	274,556,200.00	261,006,200.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(103,213,535.29)	(138,624,164.93)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,206,171,739.78	2,469,442,895.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(746,179,696.22)	(975,008,700.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	505,333,269.30	424,495,738.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	(253,724,508.62)	(237,968,164.26)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	125,900.00	125,900.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	84,001,477.00	84,001,477.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,744,228.25)	(23,740,205.15)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	5,836,065.00	
39300	Биет бус хөрөнгө	1,635,409,753.30	1,064,369,544.37
39301	Програм хангамж	1,495,948,028.20	1,671,706,306.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(366,538,274.90)	(621,575,073.63)
39303	Бусад биет бус хөрөнгө	623,929,350.30	520,561,910.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(117,929,350.30)	(506,323,598.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,922,052,685.28	8,228,282,912.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	146,403,640.25	56,926,808.25
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	146,403,640.25	56,926,808.25
41300	Өглөг	146,403,640.25	56,926,808.25
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		294,000.00
41360	Бусад өглөг	146,403,640.25	56,632,808.25
41361	Байгууллагад төлөх өглөг	146,403,640.25	56,632,808.25

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,775,649,045.03	8,171,356,104.06
51	Засгийн газрын хувь оролцоо	9,775,649,045.03	8,171,356,104.06
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,395,677,020.85	6,395,677,020.85
51101	Өмч: төрийн	6,395,677,020.85	6,395,677,020.85
51200	Хуримтлагдсан үр дүн	3,359,823,344.18	1,755,530,403.21
51210	Өмнөх үеийн үр дүн	1,975,974,640.74	3,359,823,344.18
51220	Тайлант үеийн үр дүн	1,383,848,703.44	(1,604,292,940.97)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,148,680.00	20,148,680.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,922,052,685.28	8,228,282,912.31

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛ**

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,961,567,424.32	6,014,343,742.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,661,776,227.69	3,090,213,161.41
120	Нийтлэг татварын бус орлого	3,661,776,227.69	3,090,213,161.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,655,545,227.69	3,029,304,420.41
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,376,362,910.50	2,541,941,550.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,326,847.00	191,666,891.44
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,267,855,470.19	295,695,978.97
120005	Түрээсийн орлого	6,231,000.00	7,585,000.00
120009	Бусад орлого		53,323,741.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,299,791,196.63	2,924,130,581.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,299,791,196.63	2,924,130,581.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,299,791,196.63	2,924,130,581.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,543,412,426.16	7,483,989,008.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,543,412,426.16	7,483,989,008.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,043,164,438.27	6,036,075,990.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,485,555,980.18	1,547,256,609.00
210101	Үндсэн цалин	1,214,299,878.26	1,218,391,244.86
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,510,802.58	74,973,203.00
210104	Урамшуулал	195,745,299.34	253,892,161.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	163,443,917.48	174,003,381.38
210201	Тэтгэврийн даатгал	104,009,765.67	137,251,950.62
210202	Тэтгэмжийн даатгал	11,886,830.36	7,351,540.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,858,537.95	9,187,472.69
210204	Ажилгүйдлийн даатгал	2,971,707.59	1,837,536.93
210205	Эрүүл мэндийн даатгал	29,717,075.91	18,374,880.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,825,112.17	86,987,488.28
210301	Гэрэл, цахилгаан	55,755,017.00	64,919,093.00
210302	Түлш, халаалт	16,509,006.00	17,599,181.00
210303	Цэвэр, бохир ус	4,561,089.17	4,469,214.28
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	103,481,250.28	2,060,989,896.52
210401	Бичиг хэрэг	36,682,813.13	1,816,840,385.45
210402	Тээвэр, шатахуун	19,756,000.00	11,840,920.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	43,595,187.15	50,074,726.88
210404	Ном, хэвлэл	675,000.00	1,658,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,660,000.00	2,400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	112,250.00	178,175,264.19
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал ақталсны зардал		
2105	Нормативт зардал	297,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	297,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,331,002.00	26,492,890.00
210604	Урсгал засвар	12,331,002.00	26,492,890.00
2107	Томилолт, зочны зардал	51,436,476.00	238,832,435.20
210701	Гадаад албан томилолт	18,188,136.00	131,653,840.00
210702	Дотоод албан томилолт	23,632,440.00	32,365,082.20
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	9,615,900.00	74,813,513.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,271,944,163.14	505,793,256.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,252,720,959.14	220,920,443.70
210803	Даатгалын үйлчилгээ	12,960,204.00	12,449,597.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	229,000.00	694,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		91,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,594,000.00	166,084,750.00
210807	Газрын төлбөр	440,000.00	615,120.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		104,937,246.00
210814	Орлогын татварын зардал		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	877,849,537.02	1,395,720,033.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	52,017,348.00	65,335,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	825,832,189.02	1,330,384,383.74
212	ТАТААС	-	1,517,000.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	1,517,000.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		1,517,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,247,987.89	1,446,396,017.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,247,987.89	169,008,063.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		115,045,302.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,916,200.00	53,962,761.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	475,331,787.89	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,277,387,954.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,277,387,954.75
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,418,154,998.16	(1,469,645,266.16)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	34,306,294.72	134,647,674.81
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	34,306,294.72	134,647,674.81
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,383,848,703.44	(1,604,292,940.97)

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛ

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,693,711,954.13	6,516,236,591.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,393,920,757.50	3,592,106,010.44
120	Нийтлэг татварын бус орлого	2,393,920,757.50	3,592,106,010.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,387,689,757.50	3,585,450,514.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,376,362,910.50	2,317,908,650.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,326,847.00	172,591,421.44
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		1,094,950,443.00
120005	Түрээсийн орлого	6,231,000.00	
120009	Бусад орлого		6,655,496.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,299,791,196.63	2,924,130,581.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,299,791,196.63	2,924,130,581.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,299,791,196.63	2,924,130,581.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,691,711,954.13	6,070,661,901.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,691,711,954.13	6,070,661,901.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,137,624,961.13	4,621,125,883.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,485,555,980.18	1,547,666,605.00
210101	Үндсэн цалин	1,214,299,878.26	1,218,801,240.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,510,802.58	74,973,203.00
210104	Урамшуулал	195,745,299.34	253,892,161.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	163,443,917.48	174,003,381.38
210201	Тэтгэврийн даатгал	104,009,765.67	174,003,381.38
210202	Тэтгэмжийн даатгал	11,886,830.36	
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,858,537.95	
210204	Ажилгүйдлийн даатгал	2,971,707.59	
210205	Эрүүл мэндийн даатгал	29,717,075.91	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,975,112.18	86,987,488.28
210301	Гэрэл, цахилгаан	55,755,017.00	64,919,093.00
210302	Түлш, халаалт	16,509,006.00	17,599,181.00
210303	Цэвэр, бохир ус	4,711,089.18	4,469,214.28
2104	Хангамж, бараа материалын зардал	91,087,974.15	111,193,823.88
210401	Бичиг хэрэг	22,190,736.00	27,335,070.00
210402	Тээвэр, шатахуун	14,886,000.00	14,259,864.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	43,595,187.15	50,074,726.88
210404	Ном, хэвлэл	675,000.00	1,658,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,660,000.00	2,400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,081,051.00	15,465,563.00
2105	Нормативт зардал	3,726,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,726,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,499,914.00	35,068,930.00
210601	Багаж техник хэрэгсэл		903,000.00
210602	Тавилга		444,970.00
210604	Урсгал засвар	16,499,914.00	33,720,960.00
2107	Томилолт, зочны зардал	52,939,176.00	247,913,985.20
210701	Гадаад албан томилолт	18,188,136.00	136,653,840.00
210702	Дотоод албан томилолт	25,135,140.00	32,536,632.20
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	9,615,900.00	78,723,513.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,193,195,029.14	2,352,956,019.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,160,027,978.14	222,469,243.70
210803	Даатгалын үйлчилгээ	12,960,204.00	12,449,597.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	229,000.00	558,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		91,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		168,289,780.00
210807	Газрын төлбөр	440,000.00	615,120.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,980,000.00	1,948,482,779.25
210818	Бусад мөнгөн зарлага	17,557,847.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,201,858.00	65,335,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,201,858.00	65,335,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,554,086,993.00	1,449,536,017.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	459,136,550.00	172,148,063.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		118,185,302.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,916,200.00	53,962,761.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	434,220,350.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,094,950,443.00	1,277,387,954.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,094,950,443.00	1,277,387,954.75
213304	Хөрөнгийн		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,000,000.00	445,574,690.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	447,491,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	447,491,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	447,491,600.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		447,491,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(447,491,600.00)
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,000,000.00	(1,916,910.00)
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,000,000.00
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,000,000.00	83,090.00

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛ**

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,395,677,020.85	20,148,680.00	2,182,384,202.74	8,598,209,903.59
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,395,677,020.85	20,148,680.00	2,182,384,202.74	8,598,209,903.59
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
7	Тайлант үеийн үр дүн			1,177,439,141.44	1,177,439,141.44
8	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,395,677,020.85	20,148,680.00	3,359,823,344.18	9,775,649,045.03
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,395,677,020.85	20,148,680.00	3,359,823,344.18	9,775,649,045.03
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
15	Тайлант үеийн үр дүн			(1,604,292,940.97)	(1,604,292,940.97)
16	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,395,677,020.85	20,148,680.00	1,755,530,403.21	8,171,356,104.06

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛ**

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР		6,628,957,600.00	5,234,487,140.69	1,394,470,459.31	78.96
ЗЭЭЛИЙН ДҮН					
УРСГАЛ ЗАРДАЛ		6,628,957,600.00	5,234,487,140.69	1,394,470,459.31	78.96
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		6,472,291,700.00	5,062,339,077.69	1,409,952,622.31	78.22
Цалин, хөлс болон нэмэгдэл		1,865,343,600.00	1,547,330,699.00	318,012,901.00	82.95
Үндсэн цалин	21010100	1,444,000,000.00	1,218,465,334.86	225,534,665.14	84.38
Унаа хоолны Хөнгөлөлт	21010300	110,908,400.00	74,973,203.00	35,935,197.00	67.60
Урамшуулал	21010400	310,435,200.00	253,892,161.14	56,543,038.86	81.79
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		205,187,800.00	174,003,381.38	31,184,418.62	84.80
Тэтгэврийн даатгал	21020100	130,574,100.00	174,003,381.38	-43,429,281.38	133.26
Тэтгэмжийн даатгал		14,922,700.00	0.00	14,922,700.00	0.00
ҮОМШӨ-ний даатгал		18,653,400.00	0.00	18,653,400.00	0.00
Ажилгүйдлийн даатгал		3,730,700.00	0.00	3,730,700.00	0.00
Эрүүл мэндийн даатгал		37,306,900.00	0.00	37,306,900.00	0.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		116,369,000.00	86,987,488.28	29,381,511.72	74.75
Гэрэл, цахилгаан	21030100	59,483,100.00	64,919,093.00	-5,435,993.00	109.14
Түлш, халаалт	21030200	43,421,900.00	17,599,181.00	25,822,719.00	40.53
Цэвэр, бохир ус	21030300	13,464,000.00	4,469,214.28	8,994,785.72	33.19
Хангамж, бараа материалын зардал		186,755,600.00	111,193,823.88	75,561,776.12	59.54
Бичиг хэрэг	21040100	31,440,000.00	27,335,070.00	4,104,930.00	86.94
Тээвэр, шатахуун	21040200	10,550,000.00	14,259,864.00	-3,709,864.00	135.16
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21040300	123,428,100.00	50,074,726.88	73,353,373.12	40.57
Ном, хэвлэл	21040400	742,500.00	1,658,600.00	-916,100.00	223.38
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн үстгал, ариутгал	21040500	5,775,000.00	2,400,000.00	3,375,000.00	41.56
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	21040600	14,820,000.00	15,465,563.00	-645,563.00	104.36
Эд хогшил, урсгал засварын		252,066,700.00	246,692,630.00	5,374,070.00	97.87
Багаж, техник, хэрэгсэл	21060100	212,000,000.00	211,976,710.00	23,290.00	99.99
Тавилга	21060200	5,000,000.00	994,960.00	4,005,040.00	19.90
Урсгал засвар	21060400	35,066,700.00	33,720,960.00	1,345,740.00	96.16
Томилолт, зочны зардал		244,850,600.00	241,971,485.20	2,879,114.80	98.82
Гадаад албан томилолт	21070100	63,781,000.00	131,653,840.00	-67,872,840.00	206.42
Дотоод албан томилолт	21070200	52,249,900.00	31,594,132.20	20,655,767.80	60.47
Зочин төлөөлөгч хүлээн авах	21070300	128,819,700.00	78,723,513.00	50,096,187.00	61.11
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,501,718,400.00	2,588,823,919.95	912,894,480.05	73.93
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21080100	309,900,000.00	222,469,243.70	87,430,756.30	71.79
Даатгалын үйлчилгээ	21080300	13,500,000.00	12,449,597.00	1,050,403.00	92.22
Тээврийн хэрэгслийн татвар	21080400	636,400.00	558,000.00	78,400.00	87.68
Тээврийн хэрэгслийн оношилгоо	21080500	120,000.00	91,500.00	28,500.00	76.25
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21080600	418,830,000.00	404,157,680.00	14,672,320.00	96.50
Газрын төлбөр	21080700	700,500.00	615,120.00	85,380.00	87.81
Улсын мэдээллийн маягт хэвлэх,	21080900	2,758,031,500.00	1,948,482,779.25	809,548,720.75	70.65
Бараа үйлчилгээний бусад зардал		100,000,000.00	65,335,650.00	34,664,350.00	65.34
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	21090200	100,000,000.00	65,335,650.00	34,664,350.00	65.34
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		156,665,900.00	172,148,063.00	-15,482,163.00	109.88
Бусад урсгал шилжүүлэг		156,665,900.00	172,148,063.00	-15,482,163.00	109.88
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21320400	130,400,100.00	118,185,302.00	12,214,798.00	90.63
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21320700	26,265,800.00	53,962,761.00	-27,696,961.00	205.45

НИИТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН		6,628,957,600.00	5,232,570,230.69	1,396,387,369.31	78.94
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		0.00	1,095,327,533.00	-1,095,327,533.00	0.00
Нийтлэг татварын бус орлого		0.00	1,095,327,533.00	-1,095,327,533.00	0.00
Бусад орлого	11830100	0.00	1,095,327,533.00	-1,095,327,533.00	0.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		3,340,100,800.00	1,646,742,626.25	1,693,358,173.75	49.30
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13100100	3,340,100,800.00	1,646,742,626.25	1,693,358,173.75	49.30
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		3,288,856,800.00	2,490,500,071.44	798,356,728.56	75.73
Үндсэн үйл ажиллагаанаас санхүүжих	13500100	1,910,060,800.00	2,317,908,650.00	-407,847,850.00	121.35
Туслах үйл ажиллагааны орлогоос	13500200	1,378,796,000.00	172,591,421.44	1,206,204,578.56	12.52
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	2,000,000.00	-2,000,000.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	83,090.00	-83,090.00	0.00